



IMPACT STORY

Яринпилийн Оюунцэцэг

/СБД-ийн 16-р хороо, Эко-78 бүлгийн Ахлагч/

Бид анх 2020 онд **НҮБ-Хабитат** байгууллагаас хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын гэр хорооллын үерийг даван туулах чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд бүлгийн зохион байгуулалтанд орж эхэлсэн. Төслийн багаас бидэнд байнга сургалт хийж, идэвхжүүлж, зоригжуулж, аргазүй, мэдээллээр хангаж ирсэн нь биднийг хооронд нь илүү нягтруулж, бие биенээ сонсдог, хамтарч ажилладаг болгосон бөгөөд дараа дараагийн олон төсөл хөтөлбөрт хамрагдах боломжуудыг нээсэн. Тиймээс энэ бүхний эхлэлийг тавьсан **НҮБ-Хабитатын** төслийн багийнхандаа маш их талархаж явдаг даа.



Одоо манай бүлгийн арван айл өрхүүд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны санхүүжилттэйгээр цэвэр бохир ус, дулаан хангамжид холбогдох жишиг төсөлд хамрагдаад явж байгаа. Гүйцэтгэгчээр сонгогдсон Хатан хүч наран ХХК нь Атмор компани оруулж ирсэн материалуудыг ашиглан хийж гүйцэтгэж байгаа. Ирэх 6-р сард ашиглалтанд оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа. Манай гудамжны айл өрхүүд энэ төсөлд хамрагдах болсон гол шалгуур нь бид зохион байгуулалтанд орчихсон, бүлэг болж эвлэлдэн нэгдчихсэн байдал маань давуу тал болсон. Манай бүлгийг сонгосонд баярлаж байгаа.



Бусад иргэд, бүлгийнхэндээ хэлэхэд та бүхэн бүлэг болоогүй бол бүлгээ байгуулаарай, бүлэг байгуулсан нь илүү идэвх санаачилгатай ажиллаарай. Гудамжныаа, бүлгийнхээ айл өрхүүдийн төлөө сэтгэл зүтгэл, санаачилга гаргаад ажиллах юм бол хийх ажил зөндөө байдаг. Нэг нь санаачлаад, манлайлаад явахад дэмжээд хамтдаа явах иргэд гараад л ирдэг юм билээ.

Манай бүлгийн дараагийн алхам нь гудамжаа сайжруулж, байшингаа янзлах зорилгоор ногоон зээлд хамрагдаж ногоон гудамж, ногоон хашаа байгуулахаар зорьж байгаа.